

Шинэ төрлийн Корона вируст өвчний тархалтаас хамгаалах хөл хорионы нөлөөгөөр компаний үйл ажиллагаа түр зогссон болон ажилгүй болсны улмаас амьжиргааны орлого хүндрэлтэй байгаа иргэдэд зориулав


Орлого хүндрэлтэй байгаа иргэдэд түр зээлийг яаралтай олгох тухай танилцуулга

Жирийн нөхцөлд Япон улсын хот, мужуудад нийгмийн халамжийн байгууллага нь бага орлоготой айл өрхөд зориулан амьжиргааны хэрэгцээт мөнгийг зээлээр олгох “Нийгмийн халамжийн зээлийн систем”-ийг хэрэгжүүлдэг.

Шинэ төрлийн Корона вируст өвчний тархалтаас хамгаалах хөл хорионы үед дээр дурдсан нийгмийн халамжийн системээр зээл олгох хүрээг өргөтгөхөөр шийдвэрлэсэн. Үүнд хөл хорионы нөлөөгөөр компаний үйл ажиллагаа түр зогссон болон ажилгүй болсны улмаас амьжиргааны орлого хүндрэлтэй байгаа иргэдэд зориулан бага хэмжээний зээлийн мөнгийг яаралтай онцгой нөхцлийн зээл болгож олгоно.

Онцгой нөхцлийн зээлийн тодорхой агуулгыг дор дурдах тайлбарт хавсаргав.

Зээл олгох журам



- Өргөдөл авч эхлэх хугацаа: 3-р сарын 25-ны өдөр /Лхагва/
- Өргөдлийг хүлээх авах: Оршин суугаа хот, дүүрэг, тосгоны Нийгмийн халамжийн байгууллага

Компаний үйл ажиллагаа зогсож, орлого нь буурсан иргэдэд (Бага хэмжээний зээлийг яаралтай олгох)

Жирийн үеийн нөхцлийг өөрчлөн сулруулсныг **улаанаар** бичиж тэмдэглэв.

Түр хугацаанд өрхийн орлого гэнэт буурч, хүндрэлд орсон тохиолдолд бага хэмжээний мөнгийг зээлээр олгоно.

■ Хамрагдах иргэд, өрх

Корона вируст өвчний нөлөөгөөр компаний үйл ажиллагаа зогсож, орлого буурсны улмаас өрхийн амьжиргаа түр зуур, гэнэт хүндрэлтэй болсноос зээл авах шаардлагатай өрх.

※ Жирийн үед бага орлоготой өрхийг тодорхойлдог зарчмыг өргөтгөсөн.

※ Корона вируст өвчний нөлөөгөөр орлого багассан бол компаний үйл ажиллагаа зогсоогүй байсан ч хамрагдана.

■ Зээлийн дээд хэмжээ

• Сургууль зэрэг байгууллага амарсны улмаас, мөн хувиараа хөдөлмөр эрхлэгч ажилгүй болсон зэрэг тусгай нөхцөлд 200 000 иен хүртэл.

• Үүнээс бусад тохиолдолд 100 000 иен хүртэл.

※ Жирийн үеийн 100 000 иен хүртэлх нөхцлийг өргөтгөсөн.

■ Эргэн төлөлтийг хойшлуулж болох хугацаа

1 жилийн дотор

※ Жирийн үеийн 2 сарын доторх хугацааг өөрчилсөн.

■ Зээлийг эргэн төлөх хугацаа

2 жилийн дотор

※ Жирийн үеийн 12 сарын доторх хугацааг өөрчилсөн.

■ Зээлийн хүү, батлан даагч
Хүүгүй, батлан даагч хэрэггүй.

■ Өргөдөл мэдүүлэх байгууллага
Оршин суугаа хот, дүүрэг, тосгоны
Нийгмийн халамжийн байгууллага

Ажилгүй болсны улмаас орлого нь буурсан иргэдэд зээл олгох /Ерөнхий дэмжлэгийн зээл/

※ Ерөнхий дэмжлэгт багтах амьжиргааны дэмжлэг.

Дахин ажилд орох хүртэлх хугацаанд хэрэглэх амьжиргааны мөнгийг зээлээр олгоно.

■ Хамрагдах иргэд, өрх

Корона вируст өвчний нөлөөгөөр орлого буурсан болон ажилгүй болсны улмаас өрхийн амьжиргаа хүндрэлтэй болсон өрх.

※ Жирийн үед бага орлоготой өрхийг тодорхойлдог зарчмыг өргөтгөсөн.

※ Корона вируст өвчний нөлөөгөөр орлого багассан бол компаний үйл ажиллагаа зогсоогүй байсан ч хамрагдана.

■ Зээлийн дээд хэмжээ

- (Ам бүлийн тоо 2-оос дээш бол) 2 сард 200 000 иен хүртэл.
 - (Ганц бие бол) 1 сард 100 000 иен хүртэл.
- Зээл олгох хугацааны хязгаар: Үндсэндээ 3 сар хүртэл

■ Эргэн төлөлтийг хойшлуулж болох хугацаа

1 жилийн дотор

※ Жирийн үеийн 6 сарын доторх хугацааг өөрчилсөн.

■ Зээлийг эргэн төлөх хугацаа 10 жилийн дотор

■ Зээлийн хүү, батлан даагч Хүүгүй, батлан даагч хэрэггүй.

※ Жирийн үед “Батлан даагчтай бол хүүгүй, батлан даагчгүй бол 1.5% хүүтэй байсан нөхцлийг өөрчилсөн.

■ Өргөдөл мэдүүлэх байгууллага Оршин суугаа хот, дүүрэг, тосгоны Нийгмийн халамжийн байгууллага

Анхааруулга: Зээл авагч нь үндсэндээ харьяа байгууллагаас өгөх зөвлөгөө, дэмжлэгийг хүлээн авна гэсэн нөхцөлтэйгээр зээлийг олгоно.

“Оршин суугч иргэнийн татвар”-аас чөлөөлөгдсөн байгаа бага орлоготой өрхийн хувьд орлого нь багасаад, хэсэг хугацаанд үргэлжилсэн бол зээлийг эргэн төлөхгүй байж болно хэмээн энэ удаагийн тусгай арга хэмжээнд шинээр тусгасан байна.

Web site: <http://www.dosyakyo.or.jp/access/index.html#3>